



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 70432545
Цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Б4000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.01.30 № А/02

танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗРЫН ДАРГА Б.САНДАГСҮРЭН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол, Шинэ хоршоо Чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөөг малчин өрхүүдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх чиглэлээр Засаг даргын захирамжаар бүх сумдад ажлыг хэсэг ажиллуулсан байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангах чанарыг сайжруулах тэмээчдийн хөдөлмөрийг урамшуулах зорилгоор аймгийн ИТХ-ын 2022 оны 7/10 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/71 дугаар захирамжаар бойжуулсан ботго тутамд 20.0 мянган төгрөгөөр тооцож аймгийн хэмжээнд 3750 ботгонд 75,000.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН:
ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	601,483,978.2	616,817,463.3
33	АВЛАГА	307,724,195.0	277,846,831.2
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	64,882.7
335	Бусад авлага	307,724,195.0	277,781,948.6
3351	Байгууллагаас авах авлага	288,955,296.0	251,997,405.6
3352	Хувь хүмүүсээс авах авлага	18,768,899.0	25,784,543.0
35	БАРАА МАТЕРИАЛ	293,759,783.3	338,970,632.1
351	Түүхий эд материал	21,769,230.0	11,525,000.0
35110	Тусгай зориулалттай материал	21,769,230.0	11,525,000.0
354	Хангамжийн материал	257,590,553.3	316,345,632.1
35410	Бичиг хэргийн материал	916,900.0	862,400.0
35420	Аж ахуйн материал	46,040,310.0	54,859,070.0
35430	Сэлбэг хэрэгсэл	2,200,000.0	8,810,000.0
35440	Түлш, шатах тослох материал	2,040,000.0	7,460,000.0
35470	Бусад хангамжийн материал	206,393,343.3	244,354,162.1
35600	Мал амьтад	14,400,000.0	11,100,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	545,279,909.9	505,491,826.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	545,279,909.9	505,491,826.8
392	Биет хөрөнгө	436,105,209.8	397,017,126.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	86,060,080.0	86,060,080.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,737,339.2)	(7,171,674.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	233,953,527.0	287,105,527.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(177,168,077.4)	(232,243,069.7)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,756,448.6	95,138,648.6
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,031,137.2)	(48,008,802.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,452,258.5	23,362,258.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,745,805.5)	(12,812,750.3)
39214	Бусад үндсэн хөрөнгө	462,073,386.5	462,973,386.5
39215	Хуримтлагдсан элэгдэл	(195,508,131.6)	(257,386,477.2)
393	Биет бус хөрөнгө	109,174,700.1	108,474,700.1
39301	Програм хангамж	6,800,000.0	6,800,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,024,999.9)	(3,724,999.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	105,399,700.0	105,399,700.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,146,763,888.1	1,122,309,290.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,146,763,888.1	1,122,309,290.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,146,763,888.1	1,122,309,290.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,184,787,877.4	1,184,787,877.4
51101	Өмч: - төрийн	1,184,787,877.4	1,184,787,877.4
512	Хуримтлагдсан үр дүн	(127,342,624.2)	(151,797,222.1)
51210	Өмнөх үеийн үр дүн	(70,011,437.3)	(127,342,624.2)

51220	Тайлант үеийн үр дүн	(57,331,186.9)	(24,454,597.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,318,634.9	89,318,634.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,146,763,888.1	1,122,309,290.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,165,374,399.0	1,280,924,264.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	339,305,881.3	212,136,432.2
120	Нийтлэг татварын бус орлого	339,305,881.3	212,136,432.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	339,270,881.3	212,031,432.2
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	339,270,881.3	212,031,432.2
120009	Бусад орлого	35,000.0	105,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	826,068,517.7	1,068,787,832.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714,260,700.0	968,712,742.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,260,700.0	968,712,742.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,807,817.7	100,075,090.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,395,600.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,271,000.0	94,340,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,558,649.7	2,469,480.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,582,568.0	3,265,610.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,222,630,585.9	1,188,732,018.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,222,630,585.9	1,188,732,018.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,659,847.5	1,009,447,479.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,948,940.9	572,325,595.0
210101	Үндсэн цалин	252,577,715.7	359,034,366.7
210102	Нэмэгдэл	124,478,188.1	162,107,027.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,323,500.0	32,527,104.0
210104	Урамшуулал	41,569,537.1	18,657,097.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,344,095.8	71,081,917.3
210201	Тэтгэврийн даатгал	37,633,999.1	48,379,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,427,499.3	5,691,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,541,999.2	2,780,917.3
210204	Ажилгүйдлийн даатгал	885,499.1	2,845,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,855,099.1	11,383,600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,271,026.6	36,244,095.1
210301	Гэрэл, цахилгаан	1,573,622.6	2,315,789.1
210302	Түлш, халаалт	13,342,404.0	33,869,200.0
210303	Цэвэр, бохир ус	355,000.0	59,106.0
2104	Хангамж, бараа материалын зардал	73,018,501.2	38,345,460.0
210401	Бичиг хэрэг	3,473,828.7	6,261,300.0
210402	Тээвэр, шатахуун	46,598,801.1	21,660,870.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,570.0	293,950.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,623,501.4	10,129,340.0
210408	Бараа материал акталсны зардал	6,679,800.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	420,000.0
210604	Урсгал засвар	-	420,000.0
2107	Томилолт, зочны зардал	18,626,100.0	18,964,350.0
210702	Дотоод албан томилолт	18,626,100.0	18,964,350.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,136,564.0	160,441,126.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,857,300.0	152,303,546.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	472,500.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	346,600.0	340,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,164.0	282,880.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	26,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,230,000.0	7,488,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,314,619.0	111,624,936.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,342,762.3	15,927,093.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,971,856.7	95,697,843.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	313,970,738.3	179,284,538.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,530,200.0	91,709,800.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,400,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,495,200.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	84,669,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,035,000.0	1,640,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	283,440,538.3	87,574,738.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	283,440,538.3	87,574,738.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,256,186.9)	92,192,246.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	75,000.0	116,646,844.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	34,173,057.6
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	75,000.0	82,473,786.4
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(75,000.0)	(116,646,844.0)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,331,186.9)	(24,454,597.9)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.4	89,318,634.9	-65,176,537.4	1,199,260,174.9
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-4,834,899.9	-4,834,899.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.4	89,318,634.9	-70,011,437.3	1,194,425,275.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	9,669,800.0	0.0	0.0	9,669,800.0

C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-57,331,186.9	-57,331,186.9
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,184,787,877.4	89,318,634.9	-127,342,624.2	1,146,763,888.1
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,184,787,877.4	89,318,634.9	-127,342,624.2	1,146,763,888.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,184,787,877.4	89,318,634.9	-127,342,624.2	1,146,763,888.1
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-24,454,597.9	-24,454,597.9
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,184,787,877.4	89,318,634.9	-151,797,222.1	1,122,309,290.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,051,727,736.7	1,132,127,228.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.0	105,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.0	105,000.0
120009	Бусад орлого	35,000.0	105,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,051,692,736.7	1,132,022,228.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714,260,700.0	968,712,742.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714,260,700.0	968,712,742.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	337,432,036.7	163,309,486.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,395,600.0	-
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,271,000.0	94,340,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,253,242.7	2,469,480.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	237,512,194.0	66,500,006.4
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,051,727,736.7	1,132,127,228.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,051,727,736.7	1,132,127,228.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,756,998.4	952,842,690.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,667,839.9	579,172,499.0
210101	Үндсэн цалин	271,296,614.7	365,881,270.7
210102	Нэмэгдэл	124,478,188.1	162,107,027.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,323,500.0	32,527,104.0
210104	Урамшуулал	41,569,537.1	18,657,097.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,344,095.8	71,146,800.0
210201	Тэтгэврийн даатгал	37,633,999.1	48,379,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,427,499.3	5,691,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,541,999.2	2,845,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	885,499.1	2,845,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,855,099.1	11,383,600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,502,026.6	36,937,095.1
210301	Гэрэл, цахилгаан	1,573,622.6	2,315,789.1
210302	Түлш, халаалт	13,342,404.0	33,869,200.0

210303	Цэвэр, бохир ус	586,000.0	752,106.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,217,970.0	20,641,670.0
210401	Бичиг хэрэг	2,196,600.0	457,500.0
210402	Тээвэр, шатахуун	31,933,200.0	19,679,320.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,570.0	293,950.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,600.0	210,900.0
2105	Нормативт зардал	69,400.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,400.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,005,610.0	32,035,410.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,972,510.0	15,065,600.0
210604	Урсгал засвар	33,100.0	16,969,810.0
2107	Томилолт, зочны зардал	18,626,100.0	18,964,350.0
210702	Дотоод албан томилолт	18,626,100.0	18,964,350.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,701,856.0	192,347,766.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,323,592.0	184,210,186.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	472,500.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	346,600.0	340,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,164.0	282,880.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	26,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,329,000.0	7,488,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,622,100.0	1,597,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,622,100.0	1,597,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	313,970,738.3	179,284,538.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,530,200.0	91,709,800.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,400,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,495,200.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	84,669,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,035,000.0	1,640,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	283,440,538.3	87,574,738.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	283,440,538.3	87,574,738.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	968,712,800.0	943,795,214.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	968,712,800.0	943,795,214.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,997,500.0	852,085,414.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,172,500.0	579,172,499.0
210101	Үндсэн цалин	375,736,900.0	365,881,270.7
210102	Нэмэгдэл	143,748,200.0	162,107,027.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,259,100.0	32,527,104.0

210104	Урамшуулал	16,428,300.0	18,657,097.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,146,800.0	71,146,800.0
210201	Тэтгэврийн даатгал	48,379,800.0	48,379,800.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,691,800.0	5,691,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,845,800.0	2,845,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,845,800.0	2,845,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,383,600.0	11,383,600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,091,000.0	36,937,095.1
210301	Гэрэл, цахилгаан	2,325,500.0	2,315,789.1
210302	Түлш, халаалт	33,869,200.0	33,869,200.0
210303	Цэвэр, бохир ус	896,300.0	752,106.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,781,500.0	20,451,670.0
210401	Бичиг хэрэг	457,500.0	457,500.0
210402	Тээвэр, шатахуун	19,489,800.0	19,489,320.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,623,300.0	293,950.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	210,900.0	210,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,036,100.0	32,035,410.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,065,600.0	15,065,600.0
210604	Урсгал засвар	16,970,500.0	16,969,810.0
2107	Томилолт, зочны зардал	18,205,500.0	18,154,350.0
210702	Дотоод албан томилолт	18,205,500.0	18,154,350.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,967,000.0	92,590,490.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,687,900.0	84,452,910.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	141,500.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.0	340,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,900.0	282,880.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	26,700.0	26,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,488,000.0	7,488,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,597,100.0	1,597,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,597,100.0	1,597,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,715,300.0	91,709,800.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,715,300.0	91,709,800.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.0	5,400,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	84,669,800.0	84,669,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,645,500.0	1,640,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	968,712,742.0	943,795,214.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	968,712,742.0	943,795,214.1
122005	Орон нутгийн төсвөөс	968,712,742.0	943,795,214.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	26.0	25.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.0	24.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0

620002	Гүйцэтгэх ажилтан	19.0	18.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,757,276.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,757,276.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,757,276.00
2104	Хангамж, бараа материалын зардал	190,000.00
210402	Тээвэр, шатахуун	190,000.00
2107	Томилолт, зочны зардал	810,000.00
210702	Дотоод албан томилолт	810,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,757,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,757,276.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100,757,276.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,757,276.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,340,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,469,480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,947,796.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4 зөрчил илэрч 107,384.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж баталгаажуулав.Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд тоон үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлснээр жинхэнэ зардал, тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдсэнийг залрууллаа.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их боловч материаллаг бус зөрчил гэж үзсэн тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 275,454.9 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 25,784.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 249,670.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Албан тушаалтны буруу шийдвэрийн улмаас цалин шимтгэлийн нөхөн олговор олгож байгууллагад 25784.5 мянган төгрөгийн хохирол учирсан нь Төрийн албаны тухай хуулийн 50.1. “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 6.4.8.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага бичнэ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны 10 дугаар сард ашиглалтад орсон барилга байгууламжид үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Шинээр баригдсан барилга байгууламжийг үндсэн хөрөнгөд бүртгэх талаар холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэр гаргуулан бүртгэх.

3.2.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Европын холбоо болон НҮБ-ын ХХАА байгууллагаас ирсэн Ланд круйзер 76 авто машиныг 2021 оны 1 сард хүлээн авч 2024 оноос эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд үндсэн хөрөнгөд бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага' гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа автомашиныг үндсэн хөрөнгөд бүртгэх талаар холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэр гаргуулах.

3.2.3 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баялаг буянт ХХК-тай төлбөр барагдуулах гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан хуваариар төлбөрийг барагдуулж авлага бууруулаагүй, гэрээг дүгнээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төлбөр барагдуулах тухай 2023 оны 06 дугаар сарын 09-ний №01 гэрээний 3.1, 3.3 дахь заалт, хавсралтаар баталсан төлбөр барагдуулах хуваарь

Өгсөн зөвлөмж: Баялаг буянт ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж 2025 ондоо багтааж авлага барагдуулах шуурхай арга хэмжээ хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хүнс хөдөө аж ахуйн газар	Санхүүгийн тайланд тоон үзүүлэлтүүдийг зөрүүтэй илэрхийлсэн.	1	107,384.7			1	107,384.7	1	107,384.7				
Нийт дүн		1	107,384.7			1	107,384.7	1	107,384.7				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хүнс хөдөө аж ахуйн газар	Барилга байгууламж үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй	1						1			
	Автомашин үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй	1						1			
	Гэрээнд заасан хуваариар төлбөрийг барагдуулж авлага бууруулаагүй	1	249,670.4					1	249,670.4		
	Байгууллагад учирсан хохирлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй.	1	25,784.5				1	25,784.5			
Нийт дүн		4	275,454.9			1	25,784.5	3	249,670.4		